



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ НЬ

2024.00.00
хот

Улаанбаатар

Нэхэмжлэгч: Оршин суугаа хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрын дугаар, утасны дугаар

Хариуцагч: Оршин суугаа хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрын дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: **Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох**

Миний бие А.Баттай 2010 онд танилцаж, 2011 оноос хамтран амьдарсан. Бидний хүү Б.Мөнх 2013 оны 07 сарын 10-ны өдөр төрсөн. Хүүгээ төрхөд бид Баянгол дүүргийн Иргэний бүртгэлийн хэлтсээс төрсний гэрчилгээг нь авч, хүү маань эцгээрээ овоглосон.

Бид зан харьцаа, гэр бүлээс гадуурх харилцаанаас болж 2014 оны 12 сараас тусдаа амьдарч байгаа бөгөөд цаашид хамтран амьдрах боломжгүй болсон. Хүү Б.Мөнх нь энэ жил 1 дүгээр ангид суралцаж байгаа бөгөөд хичээлийн хэрэгсэл, хувцас, бусад зардлуудыг миний бие ганцаар хариуцахад хүндрэлтэй байна.

Иймд 2013 оны 07 сарын 10-ны өдөр төрсөн хүү Б.Мөнхөд эцгээс нь хүүхдийн тэтгэлэг тогтоож өгнө үү.

ЖИЧ: НЭХЭМЖЛЭЛИЙГ 2 ХУВЬ ӨГНӨ.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалт:

1. Миний иргэний үнэмлэхийн хуулбар /нотариатчаар гэрчлүүлсэн/
2. Хүү Г.Д-ийн төрсний гэрчилгээний хуулбар /нотариатчаар гэрчлүүлсэн/
3. Хүүхэд эрүүл бойжиж байгаа тухай Өрхийн эрүүл мэндийн төвийн Эмнэлэгийн магадлагаа /Эх хувь/
4. Хүүхэд сургуульд суралцдаг тухай тодорхойлолт /Эх хувь/
5. Миний оршин суугаа хорооны Засаг даргын тодорхойлолт /Эх хувь/
6. Улсын тэмдэгтийн хурааж төлсөн баримт Жич: Тэтгэлэг тогтоолгох шаардлагад тэмдэгтийн хураамж 70200 төгрөг төлнө.

Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Gegece системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.

Нэхэмжлэл гаргасан:

Нэр ... гарын үсэг ... гарын үсгийн тайлал